



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/151

Улаанбаатар хот

Зуслан, ногоон бүсийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоол, 2012 оны 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дулааны улирал ирж айл өрх, иргэд оршин суугчид зуслан, ногоон бүсэд амарч зугаалж байгаатай холбогдуулан зуслан, ногоон бүсийн их цэвэрлэгээний ажлыг 2017 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсугай.
2. Бүх нийтийн их цэвэрлэгээнд хяналт тавих ажлын хэсгийг нэгдүгээр, цэвэрлэгээ хийх байршил, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Цэвэрлэгээний ажлыг хариуцсан хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд оршин суугчид, их дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг өргөнөөр хамруулж, хог хаягдлын үйлчилгээ үзүүлж буй Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудтай хамтарч ажиллахыг цэвэрлэгээ зохион байгуулах хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Зуслан, ногоон бүсийн их цэвэрлэгээнд Иргэдийн бүлгийг идэвхтэй оролцуулж цэвэрлэгээнээс гаргасан хог хаягдлыг уртасгасан цагаар тээвэрлэхийг Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 /Ж.Мөнх-Од, Д.Нэргүй, Х.Өлзийхорол, Э.Хатанбаатар/-т тус тус үүрэг болгосугай.
5. Зуслангийн бүсэд хамаарах Сэлбэ гол, Улиастай гол, Туул гол дагуу цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Дэд бүтэц, хот төлөвлөлтийн асуудал хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч Т.Батцогтод үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВДАВАА